



**МОНГОЛ-ОРОСЫН
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ
УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 12 сарын 26 өдөр

Дугаар A/971

Улаанбаатар хот

┌ Дамжин өнгөрөх ачаа тээврийн тарифын
хөнгөлөлтийн хэмжээг өөрчлөх тухай ┐

Хувь нийлүүлсэн нийгэмлэг “Улаанбаатар төмөр зам”-ын дүрмийн 22 дугаар зүйлийн “а” заалт, Ерөнхий хорооны хурлын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. УБТЗ-ын даргын 2009 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн “Тээврийн тарифын зохицуулалтын тухай” А/146 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх ачаа тээврийн тарифын өөрчлөлтийг 1 дүгээр, 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн “Тарифын өөрчлөлтийн тухай” А/36 дугаар тушаалаар батлагдсан Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх их даацын чингэлэг тээврийн тарифын өөрчлөлтийг 2 дугаар, Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх их даацын чингэлгийг 20 футийн чингэлэгт шилжүүлэх аргачлалыг 3 дугаар, Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх чингэлгийн галт тэрэгний бүрэлдэхүүн дэх чингэлгийг УБТЗ-ын харьяа ачиж буулгах ангиудад цуглуулж, хадгалсан хадгалалтын нэг хоногийн хураамжийг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус батлан 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Нэг илгээгч (зууч) тухайн хуанлийн сард 600 ба түүнээс дээш Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх ачаатай 20 футийн чингэлэг тээвэрлэвэл энэхүү тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан тарифыг 25 хувь хөнгөлөн тооцсугай.

3. Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх чингэлгийн галт тэрэгний бүрэлдэхүүн дэх чингэлэг тээврийн хөлсийг тооцохдоо энэхүү тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан тарифыг 12 хүртэлх хувиар хөнгөлөн тооцсугай.

4. Энэ тушаалыг хэрэгжүүлэхдээ холбогдох алба, ажилтнуудад тараах, зааварчилгаа өгөх, программ хангамжид зохих өөрчлөлтийг оруулах, тарифын өөрчлөлтийг www.ubtz.mn цахим хуудсанд байршуулахыг Эдийн засаг, санхүү хариуцсан замын орлогч дарга бөгөөд Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны дарга (Усольцева С.Я), Төлөвлөлт, эдийн засгийн албаны дарга (З.Энхбаяр), Тээвэр зохион байгуулалтын албаны дарга (Ц.Ариунболд), Статистик бүртгэлийн төвийн дарга (Д.Тамир), Мэдээллийн технологийн албаны дарга (Х.Анар) нарт даалгасугай.

5. Тушаал батлагдсантай холбогдуулан УБТЗ-ын даргын 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/594 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

6. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг Тээвэрлэлт, хөдөлгөөн хариуцсан замын орлогч дарга (Д.Амарбаясгалан)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН

1601236540

Монголын Улсын нутгаар дамжин өнгөрөх ачаа тээврийн тариф

ОХУ-аас БНХАУ-ын чиглэлд (тэгш)

Ачааны бүлэг	Хэмжих нэгж	Нэгдсэн нэвтрэх тариф (ЕТТ)	Нэгдсэн нэвтрэх тарифаас тооцох хөнгөлөлтийн хэмжээ	Нэгдсэн нэвтрэх тарифаас хөнгөлөлт тооцсон тариф	Тээвэрлэгчид үл харьяалагдах вагоноор ачаа тээвэрлэхэд үзүүлэх хөнгөлөлт	Тээвэрлэгчид үл харьяалагдах вагоноор ачаа тээвэрлэх тариф
1-р бүлэг үүнээс: нефтийн төрлийн бүтээгдэхүүн	шв.фр.тонн	51.20	50%	25.60	15%	21.76
2-р бүлэг үүнээс: мод	шв.фр.тонн	51.20	30%	35.84	15%	30.46
3-р бүлэг	шв.фр.тонн	25.70	30%	17.99	15%	15.29
	шв.фр.тонн	25.70	15%	21.85	15%	18.58
	шв.фр.гол	54.80	0%	54.80	-	-

Ачааны бүлэг	Хэмжих нэгж	Нэгдсэн нэвтрэх тариф (ЕТТ)	Тээвэрлэгчид үл харьяалагдах вагоноор ачаа тээвэрлэхэд үзүүлэх хөнгөлөлт	Тээвэрлэгчид үл харьяалагдах вагоныг хоосноор тээвэрлэх тариф	Тээвэрлэгчид үл харьяалагдах вагоноор ачаа тээвэрлэх тариф (хоосон гүйлтийг оролцуулан)
1-р бүлэг. Түүхий нефть	ам.доллар.тонн	23.25	15%	19.76	1.98
					21.74

БНХАУ-аас ОХУ-ын чиглэлд (сондгой)

Ачааны бүлэг	Хэмжих нэгж	Нэгдсэн нэвтрэх тариф (ЕТТ)	Нэгдсэн нэвтрэх тарифаас тооцох хөнгөлөлтийн хэмжээ	Нэгдсэн нэвтрэх тарифаас хөнгөлөлт тооцсон тариф	Тээвэрлэгчид үл харьяалагдах вагоноор ачаа тээвэрлэхэд үзүүлэх хөнгөлөлт	Тээвэрлэгчид үл харьяалагдах вагоноор ачаа тээвэрлэх тариф
1-р бүлэг	шв.фр. тонн	51.20	50%	25.60	15%	21.76
2-р бүлэг	шв.фр. тонн	25.70	50%	12.85	15%	10.92
үүнээс: кокс	шв.фр. тонн	25.70	40%	15.42	15%	13.11
3-р бүлэг	шв.фр. 1голд	54.80	0%	54.80	-	-
Нэг гол дээрхи цэвэр жин нь 12.5 тонноос багагүйгээр задгай хөдлөх бүрэлдэхүүнд ачигдаж байгаа 1-р бүлгийн ачааны тариф:						
1-р бүлэг.	шв.фр тонн	51.2	67%	16.90	15%	14.36

Ачааны бүлэг	Хэмжих нэгж	Нэгдсэн нэвтрэх тариф (ЕТТ)	Нэгдсэн нэвтрэх тарифаас тооцох хөнгөлөлтийн хэмжээ	Нэгдсэн нэвтрэх тарифаас хөнгөлөлт тооцсон тариф
Тээвэрлэгчид үл харьяалагдах вагоныг хоосноор тээвэрлэх	шв.фр. 1гол-км	0.1	70%	0.03



Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх их даацын чингэлэг тээврийн тариф

Чиглэл	Ачаатай					Хоосон				
	чингэлгийн төрөл					чингэлгийн төрөл				
	10 фут	10 фут-ээс их 20 фут хүртэлх	20 фут-ээс их 30 фут хүртэлх	30 фут-ээс их 40 фут хүртэлх	40 фут-ээс их	10 фут	10 фут-ээс их 20 фут хүртэлх	20 фут-ээс их 30 фут хүртэлх	30 фут-ээс их 40 фут хүртэлх	40 фут-ээс их
	шв.фр./чингэлэг	шв.фр./чингэлэг	шв.фр./чингэлэг	шв.фр./чингэлэг	шв.фр./чингэлэг	шв.фр./чингэлэг	шв.фр./чингэлэг	шв.фр./чингэлэг	шв.фр./чингэлэг	шв.фр./чингэлэг
ОХУ-аас БНХАУ-ын чиглэлд	190	380	570	760	920	95	190	285	380	460
БНХАУ-аас ОХУ-ын чиглэлд	190	380	570	760	920	95	190	285	380	460

Жич: Тусгай зориулалтын их даацын чингэлгийн тээврийн хөлсийг "Нэгдсэн нэвтрэх тариф"-ын 17 дугаар бүлгийн дагуу тооцно.

УБТЗ-ын даргын 2023 оны 12 дугаар
сарын 26 -ны өдрийн 197 тоот
тушаалын гуравдугаар хавсралт

Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх их даацын
чингэлгийг 20 футын чингэлэгт шилжүүлэх аргачлал

Чингэлгийн төрөл	20 футын чингэлэгт шилжүүлэхэд
2 x 10 фут	1 x 20 фут
1 x 30 фут	1 x 20 фут
2 x 30 фут	3 x 20 фут
1 x 40 фут	2 x 20 фут
1 x 45 фут	2 x 20 фут

Жич: Сондгой 1x10 футын чингэлгийг тооцохгүй.

УБТЗ-ын даргын 2023 оны 12 дугаар
сарын 28-ны өдрийн 199/ тоот
тушаалын дөрөвдүгээр хавсралт



Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх чингэлгийн галт тэрэгний
бүрэлдэхүүн дэх чингэлгийг УБТЗ-ын харьяа ачиж буулгах ангиудад
цуглуулж, хадгалсан хадгалалтын 1 хоногийн хураамж

№	Нэмэлт ажил үйлчигээ	Чингэлгийн төрөл		Хөлс, шв.франк/1чингэлэг
1	Чингэлэг хадгалалт	Ачаатай	2.5 фут хүртэл	0.57
			2.5 фут буюу түүнээс дээш 10 фут хүртэл	1.14
			10фут	2.27
			10 фут-ээс их 20 фут хүртэлх	4.09
			20 фут-ээс их 30 фут хүртэлх	5.00
			30 фут-ээс их 40 фут хүртэлх	5.91
			40 фут-ээс их	7.05
2		Хоосон	2.5 фут хүртэл	0.28
			2.5 фут буюу түүнээс дээш 10 фут хүртэл	0.57
			10фут	1.14
			10 фут-ээс их 20 фут хүртэлх	2.05
			20 фут-ээс их 30 фут хүртэлх	2.50
			30 фут-ээс их 40 фут хүртэлх	2.95
			40 фут-ээс их	3.52

Тайлбар: Дээрх чингэлэг хадгалалтын хураамжийн хугацааг Тарифын
1-р мөрдлөгийн 10.1.2-ын дагуу тооцно